

2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Есдүгээр сард 60 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 7 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 110 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл 19 (ажил хүсэх-9, гэр-6, малжуулалт-4) байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2022 оны 05 сарын 01-ээс “Цахим гарын үсгийн тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш 16-аас дээш насны 440 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нарт хуулийн этгээдийн гэрчилгээг ажлын 15 хоногт багтаан өөрчлөлт оруулах тухай мэдээлэл өглөө.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр

Төрсний бүртгэл -20 /эр- 12/

Нас барсны бүртгэл -10 /эр-9/

Гэрлэсний бүртгэл -3

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-1

Иргэний үнэмлэх 16 - 14 /эр-6/

Иргэний үнэмлэхний сунгалт 25,45 – 45 /эр-19/

Шилжилт хөдөлгөөн

Баг хороо хоорондын -1

Сум, дүүрэг хоорондын – 12

Нийслэл, аймаг хоорондын -13

Нийт шилжин ирсэн – насанд хүрэгч 26 /эр-14/, насанд хүрээгүй хүүхэд-24

Гэрчилгээ, лавлагаа олголт

Төрсний гэрчилгээ -2

Лавлагаа - 58

Төсөв санхүүгийн талаар.

Орон нутгийн татварын орлого 80 хувийн биелэлтэй, 295374,8 мян төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирсэн байна. Үүнд татварын орлого нэр төрлөөр тасарч байгаа хэдий ч ан агнуурын хураамж шонхор шувуунаас зөвшөөрлийн хураамжаас орлого биелэж байна. Гэрээний дагуу 4 шонхор шувууны нийт 120,0 сая төгрөг ороод байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлууд төлөвлөгөөгөөр 491839,1 мянган төгрөгийн 15 нэр төрлийн ажил хийгдэхээс 13 нэр төрлийн ажил хийгдэж 86,6 хувийн биелэлтэй байна. Үүнд:Огтоно устгал, АҮ-ний барилгын засварын ажил хийгдээгүй байна. ОНХС-аар хийгдсэн Бага насны хүүхдийн тоглоомын талбай, ЭМТ-ийн тоног төхөөрөмж, Мал угаалын ванн-ын тус тус ажлын комисс томилон хүлээн авч шийдвэрлэсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн Жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 85 хувьтай үнэлэгдэж улсын хэмжээнд 35-р байр эзэлж амжилттай үнэлэгдсэн байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хүндэтгэлийн өргөөг цахилгаан халаагуураар холбох асуудлыг шийдвэрлэж 380кв-ын холбох хүнтэй гэрээ байгуулан ажиллах, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүллээ.

Сүхбаатар аймагт 2 өдөр үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцоо төлөвлөлт төсөвлөлт сэдвээр сургалтанд хамрагдлаа. Аймгийн засаг даргаар ахлуулсан ажлын комисст өөрсдийн хийсэн ажил, болон хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг танилцууллаа.

Эрдэнэжавхлант овоо тахилгад нэгдсэн зохион байгуулалтайгаар оролцож 4 насны морь уралдах, бөхийн бай шагналын тооцоог хийж оролцлоо.

Ахмад 2022 спортын наадамд Засаг даргын нөөц сангаас 500,0 мян төгрөгийг шийдвэрлэж сумаасаа зохион байгуулалттай оролцож тусгай байр эзэлсэн байна.

Статистикийн мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргаж, ХАА-н тооллогыг амжилттай зохион байгуулан цахимаар тайлан судалгаа хүргүүллээ.

Татварын чиглэлээр:

Татварын 9-р сарын НӨАТ тайлангийн ирцийг 100% хангуулан ажилласан.

2021 оны малын тоо толгойн албан татвар төлөөгүй иргэдийн судалгааг гаргаж 2022 оны 9 сарын 30-ны өдрийн дотор татвараа төлж дуусгах талаарх мэдэгдлийг багийн Засаг дарга нарт мэдээлэл өгсөн.

Байгаль орчны чиглэлээр:

Ногоон байгууламжийн чиглэлээр:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт, ойн зурвас, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр тарьсан модны ургалтад хяналт мониторинг

хийх, Сүхбаатар аймгийн Засаг даргын А/470 дугаар захирамжийг үндэслэн суманд Уулбаян сумын Засаг даргын А/100 дугаар захирамж гаргаж ажлын хэсэг байгуулан тарьсан модонд хяналт мониторинг хийж ургалтыг тогтоолоо. Тус ажлын хэсэгт Засаг даргын орлогчоор ахлуулсан 8 бүрэлдэхүүнтэй ажиллаж 2 хоногийн хугацаанд дуусгасан. Мөн тооллогын явцад ногоон байгууламжийн эвдэрч сүйтсэн хашааг сэргээн засварласан. Тарьсан модны ургалтын үр дүн: Байгаль орчин аялал жуулчлалын газраас дэмжлэгээр олгосон 2000 ширхэг модны ургалт 80%, ургасан мод 1613 ширхэг, ургаагүй мод 387 ширхэг, сумын нийт модны ургалтын байдал нийт таригдсан мод 5744 ширхэг, ургасан мод 5235 ширхэг, ургаагүй мод 509 ширхэг, ургалтын хувь 84.8%-тай байна гэсэн дүгнэлт гарлаа.

Мөн Уулбаян сумын засаг даргын А/100 дугаар захирамжийг үндэслэн “Ногоон байгууламж, тарьсан модонд хяналт шалгалт хийх бэлтгэл ажлыг хангуулах тухай” цэвэрлэгээний хуваарийг гарган 17н аж ахуйн нэгж байгууллагуудад тараан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан.

Гамшигаас хамгаалах, команд штабын сургалтын хүрээнд сумын онцгой комисс, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад болон Ерөнхий боловсролын сурагчдад “Газар хөдлөлтийн үеийн орон нутгийн удирдлага зохион байгуулалт, “Хүчтэй цасан болон Шороон шуурга” гэх 2 сэдвээр илтгэл, сургалт өгч газар хөдлөлт болон байгалийн давагдашгүй хүчин зүйлсэд хэрхэн бэлдэх анхан шатны мэдлэг олгосон. Тус сургалтаар Ерөнхий боловсролын сурагчид, Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилчид хамтарсан 70 хүн сургалтад хамрагдсан.


Хяналт шалгалтын чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газраас “Идлэг шонхор шувуу”-г соёлын зориулалтаар барих зөвшөөрөл олгогдсонтой холбогдуулан шувуу барих зорилго бүхий туулах чадвар сайтай машин бүхий хүмүүс тус орон нутгаар хольхих болсон. Үүнтэй холбогдуулан малчдаас ирсэн гомдол, мэдээллийн дагуу цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт шалгалт хийх ажлыг тогтмол зохион байгуулж зөрчил дутагдал илрүүлэн ажилласны үр дүнд отгийн ахлагч нартай “орон нутагтай хамтран” ажиллах гэрээ 10-г байгуулан, акт үйлдэн одоогийн байдлаар байгаль хамгаалах санд 124 сая төгрөгний орлого бүрдүүлээд байна. Мөн зохих зөвшөөрөл гарахаас өмнө идлэг шонхор шувууг барих оролдлого хийсэн зөрчлийг хяналт шалгалтын үр дүнд газар дээр нь илрүүлэн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн 1 иргэнийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хэргийн материалыг аймгийн прокурорын газарт хүргүүлээд байна.


Зөвшөөрөлгүй газар малын хашаа барьж амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна гэх гомдлын дагуу холбогдогч иргэн Отгонхүүд шаардлага тавьж зөрчлийг арилгуулав.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:


Гол нэрийн бүтээгдэхүүний Үнийн өсөлтийг 7-9 сартай харьцуулан харуулав.



Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2022 оны 09 сарын 26-ны байдлаар. Хүнсний бүтээгдэхүүний татан авалт хэвийн явагдаж байна.



2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар. Бензиний үнийг 7 сартай харьцуулахад А-92 үнэ 20 төгрөгөөр буурсан, А-80 үнэ өсөөгүй. Дизел түлшний хувьд 150 төгрөгөөр буурсан байна.



дэмжин хөгжүүлэх, сумын шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоход орших зорилготой.


Уулбаян сум “Алтан намар-2022 ” үзэсгэлэн худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 16-ний өдөр баялаг бүтээгчдийн холбоо, Соёлын төвтэй хамтран зохион байгуулсан.

Дараах 5 төрлөөр бүтээгдэхүүнийг шалгаруулсан:

1. Орон нутгийн шилдэг бүтээгдэхүүнээр /Ц.Цэгмид/
 2. Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүний төрөлд
 - 1-р байр: Б.Мөнбаяр
 - 2-р байр: Ч.Цогзолмаа,
 - 3-р байр: О.Оюунсугар
 3. Шилдэг гар урлалын төрөлд
 - 1-р байр: Э.Мөнх-Эрдэнэ
 - 2-р байр: Ж.Наранцэцэг
 4. Шилдэг эсгий эдлэлийн төрөлд
 - 1-р байр: А.Сарантуяа
 - 2-р байр: Б.Дэнсмаа
 5. Шилдэг малын гаралтай түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүний төрөлд
Э.Угтахбаяр нар тус тус шалгарсан.
- 6 төрлөөр нийт 20 баялаг бүтээгчид үзэсгэлэн худалдаанд оролцсон.

Хоршоо хөгжүүлэх сан

2022 оны 09 дугаар сарын 26-ны байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 11,546,292 төгрөг хоршоо хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлөгдсөн байна.



Эргэн төлөлтийг 8-9 сартай харьцуулахад 7%-иар өссөн байна.

Эргэн төлөлт тогтмол хийж буй зээлдэгчид:

- 2020 онд зээл авсан - Б.Цэрэнхүү, А.Отгонхүү,
- 2021 онд зээл авсан- А.Сарантуяа, Г. Нямдорж, Б.Болдбаяр, Б.Дэнсмаа, Б.Мижиддорж, М. Цолмон, З.Дорж,

Эргэн төлөлт хийхгүй байгаа зээлдэгчид:

- 2019 онд зээл авсан - Б.Сэрчмаа, Л.Мөнхнаст
- 2020 онд зээл авсан- Т.Чулуун
- 2013 онд зээл авсан - Г.Зоригт

Хугацаа хэтэрсэн зээлдэгчид

- 2013 онд зээл авсан - Г.Зоригт, Л.Эрдэнэхуяг, Ж.Мөнхтуул,
- 2016 онд зээл авсан- С.Шарав

2022 оны 1-р улиралд хаагдсан зээлүүд

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн бодлогын чиглэлээр:

1 дүгээр ангид элсэн орох 6 настануудын судалгаа мөн цэцэрлэгийн 2-5 насны хүүхдийн судалгаа нийт 5 багийн 133 хүүхдийн судалгааг гаргаж өгсөн. “Нийгмийн ажилтануудын мэдээлэлийн сан” цахим системтэй танилцаж цахимаар сургалт авсан. Залуучуудын сар аяны хүрээнд “Залуучуудын хөгжлийн үндэсний цахим чуулганд” залуучуудын салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран суусан. Эрдэнэ-жавхлант уулын тахилга наадмын хурдан морь уралдааны тайлан мэдээг хүргүүлсэн. Хамтарсан багийн үндэсний сургагч зөвлөх багш Д. Ундраа 2022 оны 09 сарын 21 нд ирж зөвлөн туслах үйлчилгээ, зөвлөгөө өгч мэдлэг мэдээлэл олж авсан. Аймгийн Засаг даргын захирамжын дагуу “Хүүхэд хамгаалын салбар дунд бүлгийн бэлэн байдлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг цэцэрлэг, сургуулиас авч нэгтгэн сар бүрийн 25-ны дотор ГБХЗХТ-рүү хүргүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Сумын хэмжээнд нийт 21 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Шимтгэлийн орлогын төлөвлөгөөг оны эхнээс аж ахуй нэгж байгууллагуудад хувиарлан төлөвлөн сумын засаг даргаар батлуулан шимтгэлийг хуулийн хугацаанд оруулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөөг багуудад хувиарлан багийн дарга нартай гэрээ байгуулан ажиллаа .Гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнэн тамгын газарт тайлагнаж үүний үр дүнд:.

Ажил олгогчийн шимтгэлд 528356,4 мян төг орохоос 465348,4 мян төг орж төлөвлөгөө 88,0%

Сайн дурын даатгалд даатгуулагч 150 хамрагдахаас 143 даатгуулагч даатгаж, шимтгэлд 58929,7 төгрөгөөс 60595,5 мян төг орж 102,8%

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд мян 35473,8 төгрөг орохоос 19874,3 мян төгрөгийн шимтгэл орж 56,0 %тай тус тус биелэж нийт мян төг нийгмийн даатгалын шимтгэл 622759,1 орохоос 545818,2 мян төг-н шимтгэл орж нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөө 87,6% -р биелэлээ.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох-22 тэтгэврээ өөрчлөн тогтоолгох- өргөдөл-6 , Банк солих-33, тэтгэмж-43, ажилгүйдлын тэтгэмж-6 , малчнаар ажилласан жилээ тогтоолгох -2 нийт 112 өргөдлийг хүлээн авч бүрэн шийдвэрлэв 652 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож, олгох ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж НДаатгалын санд 545818,2 мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлж, тэтгэврийн санд 1499000,0 мян төгрөгний санхүүжилт, тэтгэмж дээр 0,0 мян төгрөгний санхүүжилт авч,

- Тэтгэвэрт - 477 тэтгэвэр авагчдад 203283,9 мян төгрөгний тэтгэвэр,
- ХЧТА тэтгэмжинд- 21 даатгуулагчдад 2426,6 мянган төгрөг,
- Оршуулгын тэтгэмжинд- 9 тэтгэвэр авагчдад 9000,0 мян төгрөг,
- Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг- 13 даатгуулагчдад 23436,9 мян төг,

нийт 2067677,4 мян төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгоод олголтын зөрчилгүй ажиллаж байна. Зарцуулагдаагүй сангийн үлдэгдлийг НДХэлтсийн ЭМДаатгалын санд- 77798,8 мян, ҮОШМӨ санд- 21488,1 мян, Ажилгүйдлын санд - 5739,2 мян төгрөгийн шимтгэлийг 7 хоног бүр төвлөрүүлээд байна .

Ерөнхий боловсролын сургуулийн чиглэлээр:

- 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлтийг ёслолын өндөр хэмжээнд зохион байгуулж нээлтэд аймгийн Засаг даргын орлогч, сумын Засаг дарга, ахмад багш нар, эцэг эх асран хамгаалагчид оролцлоо. Мөн энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг сумын Засаг дарга олонд сонордуулж, Чингис хааны эш хөргийг залах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.
- “Сүхбаатар нэг мөрөөдөл” ТББ-ын шилдэг багш, удирдах ажилтан шалгаруулах уралдааны 2 дугаар шатны болзлыг захирал З.Эрдэнэчимэг, МХУЗ-ын багш Л.Мөнхтуяа нар хангаж дараагийн шатанд оролцох эрхтэй боллоо.
- Суурь боловсрол эзмшиж 6 дугаар ангид элсэн суралцаж буй нийт 62 сурагчдын дунд “Бид дэвшлээ” үйл ажиллагааг зохион байгуулж сурагчдад мэргэжлийн багш нарын зүгээс зөвлөгөө мэдээллийг хүргэлээ. Мөн сурагчид сурагчийн тангарагаа өргөж дунд ангийн сурагчид болцгоох алхам хийв.
- Хичээлийн “Б” байрны 743 сая төгрөгийн их засварын ажлыг Япон Улсын Элчин Сайдын Яам “Өвсний үндэс” хөтөлбөрийн санхүүжилтээр 2023 онд хийгдэхээр дэмжигдсэн.
- ЕБС-ийн номын сангийн дэргэдэх “Номын анд” клубээс номын тухай онч мэргэн үг, эшлэл бичих уралдаан зарлан дүгнэв. Уралдаанд нийт 21 хүүхэд оролцлоо.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 32 дахь жилдээ зохион байгуулагдсан “Номын баяр 2022” арга хэмжээнд идэвхтэй оролцож МХУЗ-ын багш Л.Мөнхтуяа “Шилдэг уншигч төрлөөр, Ж.Мөнх-Од багштай 26 анги хамт олон \нийт 24 хүүхэдтэй\ “Шилдэг уншигч анги”-аар шалгарлаа.

- “Номын баяр-2022” арга хэмжээг сумын Соёлын төвтэй хамтран зохион байгууллаа. Номын баярыг угтаж нийт 4 төрлийн тэмцээн уралдаан явуулж нийт 131 хүүхэд хамрагдлаа.
- Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Олон Улсын Эко хөтөлбөрийн 3 дах шатны сургалтад 5 багш, 5 сурагч хамрагдлаа.
- Дэлхийн Зөн Монгол ОУБ-тай хамтран “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Ялгаварлан гадуурхалт”, “Хүний эрх” сэдвээр багш, ажилчид тэдний гэр бүлийн дунд сургалт явуулав. Сургалтад нийт 61 хүн хамрагдлаа.

Хүүхдийн цэцэрлэгийн чиглэлээр:

- Манай цэцэрлэг нь 2022-2023 оны хичээлийн жилд 2 настай-33, 3 настай-30, 4 настай-51, 5 настай-46 хүүхдийг үндсэн 5 бүлэгт нийт 160 хүүхдийг хамруулсан ба хувилбарт сургалтад-71 хүүхдийг хамруулан сургалт үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.
- Хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл, мэрэгчгүйтгэлийг хийлгэж ажиллалаа.
- Мөн ЭМТ-тэй хамтран цэцэрлэгт хамрагдах бүх хүүхдийг цагаан хорхой болон урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамрууллаа. Цагаан хорхойн шилжилгээгээр эерэг хариутай гарсан хүүхдүүдийг 7 хоног цэцэрлэгт явуулалгүй эмчилгээ хийлгэн дахин шинжилгээ өгүүлэн сөрөг гарсан тул хүлээн авсан.
- 9.1-ны нээлтийн үйл ажиллагааны үеэр Чингис хааны эш хөргийг залах үйл ажиллагааг зохион байгуулж хүндэтгэлийн газарт байрлуулсан. Мөн нээлийн үйл ажиллагаанд өмнөх хичээлийн жилд амжилттай ажилласан 5 багш, ажилтанг шагнаж урамшууллаа.
- Боловсролын мэдээллийн системд нийт 231 хүүхдийн мэдээллийг бүрэн оруулан ажиллаж байна.
- Цэцэрлэгийн эрхлэгч 09 сарын 15-17 өдрүүдэд Баруун-Урт хотноо зохион байгуулагдсан “Хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээний арга зүй” сэдэвт сургалтад хамрагдсан.
- Дээрх сургалтын түгээн дэлгэрүүлэлтийг ажлын байранд зохион байгуулан нийт 11 багш, туслах багш нарыг хамруулан сургалт зохион байгууллаа.
- Бүх бүлгийн хүүхдүүдийн суурь судалгааг 16 төрлөөр нарийвчлан гарган нэгтгэн эрсдэлтэй болон эрсдэлт өртөж болзошгүй хүүхдүүдэд кейс нээн ажиллаж байна.
- Хүүхдийн хоолны илч нормыг сайтар тооцон хоолны цэсийг шинэчлэн хийж нэр төрлийг оршруулсан ба порцын таваг-160ш шинээр худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Соёлын төвийн чиглэлээр:

Соёл, урлагийн ажилтны өдөрт зориулсан “Соёлын орон зай” гэсэн уриатайгаар энэ жилийн арга хэмжээнүүд зохион байгуулагдаж байна. Соёлын ажилтны хүрээнд 2022 оны 09 сарын 11-нд волейболын тэмцээн зохион байгуулж нийт 6 баг оролцсон. Спортын тэмцээнд оролцсноор нийт иргэд нэг өдөр спортоор

хичээллэж түүнийг дагсан тэмцээн уралдаанд амжилттай оролцох цаашлаад нийт иргэд спортоор хичээллэх сонирхол төрүүлэхэд оршино.

2022 оны 09 сарын 12 ноос даваа гараг бүрийн 19 цагт нийтийн бүжгийг тогтсон хуваарийн дагуу байнга явуулж эхэлсэн. Үүний үр дүнд сумын нийт ард иргэд, аж ахуй нэгж байгууллагууд эрүүл мэнд **/Эрүүл биед саруул ухаан оршино/** идэвхтэй хөдөлгөөн, хоорондын уялдаа холбоо болон найрсаг харилцааг бэхжүүлнэ.

Орон нутагт кино үзвэр сэргээхээр кино тест үйл ажиллагааг **"10-0-0 mini cinema"** кино театрт хамтран **"HOWLING VILLAGE"** киног 09 сарын 14 нд туршилтаар гаргасан. Энэхүү киног 100 гаруй хүүхэд үзсэн бөгөөд туршилт амжилттай болбол сумын иргэд дэлхийд нээлтээ хийж буй шинэ киног үзэх боломжтой болох ба хөдөө орон нутгийн хүүхдүүд кино театрт кино үзэх боломж хомс байдаг тул цаашдаа стандартын дагуу кино театрт кино үзэх боломж нээгдэнэ.

Уулбаян сум **"Алтан намар 2022"** үзэсгэлэн худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Соёлын төвд амжилттай зохион байгуулагдаж орой нь үдшийн цэнгүүн болсон.

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүдэд 2022" арга хэмжээ 09 сарын 17,18-ны өдрүүдэд Сүхбаатар аймагт болж өнгөрлөө. Энэхүү арга хэмжээнд соёлын төвийн номын санч П.Ганцэцэг оролцож номын санчдын ур чадварын уралдаанд багаараа Дэд байр, **"Шилдэг афоризм"** уралдаан гутгаар байр эзэлж амжилттай оролцоод ирсэн.

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд ЕБС-ийн номын сантай хамтран 1-3 дугаар ангийн сурагчдын дунд, УРАН УНШИГЧ шалгаруулах уралдаан зохион байгуулахад нийт 42 хүүхэд хамрагдсанаас ТЭРГҮҮН" байранд 2б ангийн сурагч А.Эмүүжин, ДЭД" байранд 2а ангийн сурагч Оюунтунгалаг, ГУТГААР" байранд 1б ангийн сурагч Хонгорзул "ТУСГАЙ БАЙР"-нд . У.Номун-Эрдэнэ.нар шалгарлаа

7-9 дүгээр ангийн сурагчдын дунд МОНГОЛ БИЧГИЙН УРАЛДААН"-ыг "цэвэр сайхан бичигтэн," "Хэн хурдан зөв унших вэ" төрлүүдээр зохион байгууллаа. Уралдаанд нийт 21 сурагч оролцсоноос "ТЭРГҮҮН" байранд Э.Баярдулам, "ДЭД" байранд сурагч Н.Гүндэлмаа нар шалгарлаа

Дотуур байрын сурагчдын дунд МИНИЙ ХАЙРТАЙ ЗОХИОЛЫН БААТРУУД"" сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулахад 1-9 дүгээр ангийн 18 сурагч оролцож

ТЭРГҮҮН” байранд 6А ангийн сурагч Б.Цэлмэг, ДЭД” байранд 9а ангийн сурагч О.Анар, “ГУТГААР” байранд 7а ахгийн сурагч М.Отгонцэцэг нар шалгарлаа

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 58.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журмын 2.1 дэх хэсэг, Соёлын сайдын “Үзлэг, тооллого хийх тухай” 2021 оны А/54 дүгээр тушаалын дагуу тооллогын бэлтгэл ажил хангагдаад явж байна.

2022 оны 09 сарын 17-нд Н.Жамрсанд хүндэтгэл үзүүлэх үндэсний бөхийн барилдаан Соёлын төвд гурван насны ангилалаар болсон. Энэ барилдаанд Түвшинширээ, Баяндэлгэр сумын хүүхдүүд ирж барилдсан бөгөөд нилээн өргөн дэлгэр болсон.

Сумын шагайн холбооны тэргүүлэгч аймгийн гоц мэргэн Намсрайн Гантөмөр, Даваагийн Жигмэджамц нар “Шагайн харвааны дугуйлан хичээллүүлж байна. Дугуйланд нийт 6 сурагч хамрагдаж байна. Мөн бүжгийн багш А.Мөнгөнсүлд бүжгийн дугуйланг 18 хүүхэдийг 2 ээлжээр хичээллүүлэн ажиллаж байна

Эрүүл мэндийн чиглэлээр:

Эмнэлгийн тусламж үйлчилгээ

1. Бүгд үзлэг -2913
2. Амбулаторийн үзлэг -1440
3. Урьдчилан сэргийлэх үзлэг-1065
4. Идэвхитэй хяналт-55
5. Гэрийн эргэлт-18
6. Алсын дуудлага-119
7. үүнээс хүүхдийн дуудлага -14
8. Гэрийн дуудлага –283
9. Хэвтэн эмчлүүлсэн –232
10. үүнээс хүүхэд -93
11. Ковид-19 халдвараар--0
1. Эрт илрүүлэгийн үзлэгт
 - Артерийн гипертензи -\246
 - Чихрийн шижингийн –266
 - Хөхний эрт илрүүлэг -238

- Умайн хүзүүний эсийн шинжилгээ-51
- 2. Ковид -19 нэмэлт тунгийн вакцинжуулалт
 - 1-р тун -2036-87%
 - 2-р тун- 1927-85.9%
 - 3-р тун- 989-60.9%
 - 4-р тун -140-14,2%
- 3. Товлолт вакцинжуулалт 0-2 насны давхардсан тоогоор 30 хүүхдийг товлот дархлаажуулалтанд хугацаанд нь хамруулсан. В вирусын эсрэг вакцинжуулалтын III-р тунд 38 ,5-11 насны Ковид-19 вакцинжуулалтанд-4 хүүхэд хамрагдсан байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Шинээр томилогдсон албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлтийг бүрдүүлж, хүний нөөцийн удирлага, мэдээллийн тогтолцоо цахим системд үндсэн мэдээлэл, хөдөлмөрийн гэрээ, ажилд томилогдсон шийдвэрийг орууллаа.

Байгууллагын даргын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг бүрэн хангуулж захирамж-6, тушаал-4, албан тоот-5, удирдамж-1 тус тус боловсрууллаа.

Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архинаас татгалзах, тамхины хор уршгийн талаарх мэдээллийг олон нийтэд бичлэг, постероор мэдээллээ.

Гамшгаас хамгаалах тухай хууль, Ойн тухай хуулийн хүрээнд А5 хэмжээтэй гарын авлага боловсруулан, ерөнхий боловсролын сурагчдад тараан өглөө.